



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ


/2016 он/

Мөрөн 2016

Зоонозын халдварт өвчний эрсдэлд өртсөн тохиолдол

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар зоонозын халдварт өвчний эрсдэлд өртсөн 405 тохиолдол бүртгэгдсэнээс 325 буюу 80.2% нь галзуу өвчний эрсдэлд өртсөн, 78 буюу 19.2% нь хачигт халдварын, 2 буюу 0,5% нь тарваган тахлын сэжигтэй тохиолдол эзэлж байна. Үүнд:

Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол: Энэ онд галзуу өвчний эрсдэлд өртсөн 325 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55 тохиолдлоор буюу 16,9%-иар, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 44 тохиолдлоор буюу 13,5%-иар өндөр байв.



Хачигт халдварын хүний өвчлөлийн сэжигтэй 78 тохиолдол бүртгэгдсэний Мөрөн-23(8), Алаг-Эрдэнэ-8(2), Арбулаг-2(2), Баянзүрх 6(3), Бүрэнтогтох-6(2), Галт-6(5), Жаргал-9(3), Ренчинлхүмбэ-2(0), Тариалан-1(0), Төмөрбулаг-1(1), Улаан-Уул-3(0), Ханх -1(0), Цагаан-Үүр-6(4), Цэцэрлэг-2(1), Чандмань-Өндөр-2(1), Шинэ-Идэр-1(1), Эрдэнэбулган-2(0) сумдад тус тус бүртгэгдсэн бол 1 тохиолдол Эрдэнэт хотоос зөөвөрлөгдөн ирж бүртгэгдсэн. Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 2 тохиолдлоор буюу 2,6%-иар, харин улс, аймгийн дундажтай харьцуулбал 46 тохиолдол буюу 58.9%-иар өндөр байна.

Үйл явдалд суурилсан тандал судалгаагаар илрүүлсэн хачигт халдварын сэжигтэй 78 тохиолдлын 34 буюу 43,5% нь лабораторийн шинжилгээгээр баталгаажсан.

Тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй 2 тохиолдол бүртгэгдсэнийг тархвар судлалын заалтаар үгүйсгэсэн.

График- 1




График -2



Дархлаажуулалтын байдал


Галзуу өвчний сэжигтэй мал болон нохой, чононд хазуулж, ноцуулж, шүлсдүүлсэн тархвар судлалын заалт бүхий 325 хүнээс галзуугийн эсрэг дархлаажуулалтанд 266 буюу 81,8% хамруулж, галзуугийн эсрэг вакцин

тасарснаас хойш бүртгэгдсэн 59 хүнийг хяналтанд авч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаа. Мөн галзуугийн эсрэг ийлдэс эмчилгээнд Мөрөн сумаас-6, Их-Уул-3, Тосонцэнгэл, Цагаан-Уул сумдаас тус бүр 1 нийт 11 хүнийг хамруулсан.

Энэ жил ЗӨСҮТөвөөс хачгийн эсрэг вакцин 100 хүн тун хуваарилагдан ирж нийт 68 хүнийг хамруулснаас 52 хүнийг эхний болон давтан тунд, 3 хүнийг эхний тунд, 13 хүнийг 3-р тунд тус тус хамруулан мэдээг ЗӨСҮТөвд хүргүүлсэн.

Тарваган тахлын 1700 хүн тун вакцин хүлээн авч дархлаажуулалтанд хамрагдвал зохих 2556 хүнээс 1659 хүн буюу 64,9%-ийг хамрууллаа. Харин хуваарилагдсан вакцинаас хамрагдалтын хувийг тооцоход 97,6% байна.

График-3



Боомын эсрэг 60 хүн тун вакцин хүлээн авч хамрагдвал зохих 42 хүнээс 37 хүнийг 5-р давтан тунд хамруулан мэдээг ЗӨСҮТ-д хүргүүлсэн. Хамралтын хувь 70%

Сумдын чоно, нохой устгалын ажил

Энэ жил Арбулаг, Цагаан-Уул, Тариалан, Цагааннуур, Эрдэнэбулган, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Төмөрбулаг, Тариалан, Мөрөн, Галт, Их-Уул сумдад галзуу өвчний агуулагч болох чоно, нохой устгалын ажлыг зохион байгуулж нийт 58 хүн ажиллан 7274,6 мян.төг-ийг зарцуулан 7 чоно, 1571 нохой устгасан. Мөн гэрийн тэжээвэр 150 нохойг вакцинжуулсан.

Мал, амьтны сэжигтэй дуудлага болон өвчлөлийн байдал

Мал, амьтны нийт 30 дуудлага хүлээн авсанаас Их-Уул, Баянзүрх, Цэцэрлэг, Тосонцэнгэл, Мөрөн, Цагаан-Уул, Галт, Түнэл, Бүрэнтогтох, сумдаас мал, амьтны галзуу өвчний сэжигтэй 24 дуудлаганд (дорго-1, үнэг-2, үхэр-16,

нохой-3, хонь-1, чоно-1) үйлчилж дээрх амьтад нь галзуу өвчнөөр өвчилсөн болохыг мал эмнэлгийн лабораториор баталгаажуулсан.

Боом өвчнөөр Түнэл, Улаан-Уул, Ренчинлхүмбэ сумдад тус бүр-1 үхэр, Цагаан-Уул суманд 7 тугал өвчилж үхсэн болох нь мал эмнэлгийн лабораториор баталгаажсан 4 дуудлагыг хүлээн авч сумын онцгой комисс зааврын дагуу голомтонд хариу арга хэмжээ авч ажиллаа.

Тарваган тахалын сэжигтэй мэргэчийн 5 дуудлага /Цэцэрлэг сумын 4-р багт тарваганы 4ш, Бүрэнтогтох сумын Туяа багаас 2ш, Мөрөн сумын 10, 9-р багуудаас тус тус 1ш сэг зэм олдсон тухай/-нд үйлчилж холбогдох арга хэмжээг авав. Мөн Бүрэнтогтох сумаас хураагдсан 50 ширхэг тарвагыг халдвар хамгааллын дэглэмийн зааврын дагуу халдваргүйтгэж булж устгасан.

График-4




График-5





График-6



Мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулсан байдал:

2016 оны жилийн эцсийн байдлаар Зоонозын халдварт өвчнүүдээс сэргийлэх талаар аймгийн хэмжээнд:

ЭМБ-уудад давхардсан тоогоор 43 удаагийн 60 цагийн сургалтанд 692 эмнэлгийн ажилчдыг, 54 удаагийн ярианд 828 эмнэлгийн ажилчдыг хамруулж, ЗХӨ-ий сургалт сурталчилгаанд ашиглагдах 1744 санамж, зөвлөмж, 63 зурагт хуудас, 73 ном гарын авлагаар хангаж ажилласан.

Цэцэрлэгийн хүүхдэд давхардсан тоогоор 15 удаагийн 14 цагийн сургалтанд 418 хүүхэд, 12 удаагийн ярианд 420 хүүхдийг хамруулж, ЗХӨ-өөс сэргийлэх 211 санамж, зөвлөмж, 1 зурагт хуудас, 13ш ном тараав.

Сургуулийн хүүхдэд давхардсан тоогоор 42 удаагийн 34 цагийн сургалтанд 1142 хүүхэд, 43 удаагийн ярианд 2470 хүүхдийг хамруулж, ЗХӨ-өөс сэргийлэх 2829 санамж, 39 зурагт хуудас, 27ш ном гарын авлагыг тараав.

Ард иргэдэд давхардсан тоогоор 204 удаагийн 293 цагийн сургалтанд 3465 хүн, 923 удаагийн ярианд 14151 хүнийг хамруулж, ЗХӨ-өөс сэргийлэх 14580 ширхэг санамж, 214 зурагт хуудас, 5ш ном гарын авлагыг тараав.

Бусад байгууллагуудад давхардсан тоогоор 35 удаагийн 36 цагийн сургалтанд 576 хүн, 117 удаагийн ярианд 735 хүнийг хамруулж, ЗХӨ-ий сургалт сурталчилгааны 832 санамж, зөвлөмж, 163 зурагт хуудас, 8 ном гарын авлагаар хангасан.

График -7




График-8





График-9



Байгалийн голомт хяналтын шинжилгээ:

Тарваган тахлын голомт хяналтын шинжилгээг Цэцэрлэг, Цагаан-Уул сумдын 24 секторын 216 мянган га талбайг хамруулан гүнзгийрэл, хайгуул

хэлбэрээр 2 удаа хийж тарваган тахлын 2 өсгөвөр илрүүлэн ЗӨСҮТ-д хүргүүлэн баталгаажуулав.

Боомын голомт хяналтын шинжилгээг Галт, Жаргалант, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдад хийж, Жаргалант сумын 3-р баг Баруун эхийн Шар жалгын үхсэн үхрийн булааны шороо, Улаан толгойн хашааны өтөг бууцнаас 2 өсгөвөр илрүүлэн ЗӨСҮТ-д хүргүүлэн баталгаажуулсан.

Алаг-Эрдэнэ сумын Өвөр гялаад, баруун Жарганатын гол, Арбулаг сумын Талын нуур, Хатгал Хөвсгөл нуур, Алагцарын голд ус намгийн шувуудын хайгуул шинжилгээг хийж нийт 6 зүйлийн 368 ус намгийн шувуу тоолж тайлан мэдээг ЗӨСҮТ-д явуулав. Судалгаанд хамрагдсан нууруудад үхсэн болон өвчтэй шувууны тохиолдол тэмдэглэгдээгүй.

Хачигт халдварын хайгуул шинжилгээг Арбулаг, Алаг-Эрдэнэ, Хатгал, Чандмань-Өндөр сумдын 30 секторын 62 цэгт газарт 496 дарцаг/км ажиллуулан 7357 хачиг, хүний биед ассан 28, малаас 22 нийт 7407 хачиг цуглуулан зүйлийн бүрдлийг тодорхойлж, 3444 хачгийг түүвэрлэн бүлэглэж, ЗӨСҮТ-ийн вируслогийн лабораторит хүргүүлэн хачгаар дамжин халдварладаг 6 төрлийн үүсгэгч хайлгах шинжилгээнд хамруулахад 38 цэгт газраас цуглуулсан 75 бүлэг хачгийн сорьцноос хачигт риккетсиозийн үүсгэгч илэрсэн. Хөвсгөл нуурын баруун тал ...4534-р сектор буюу Хирбистэгийн амнаас *I.persulcatus* зүйлийн нэг ширхэг хачиг түүвэрлэн тодорхойлон ЗӨСҮТ-ийн шимэгч судлалын лабораторит хүргүүлэв.

Шумуулаар дамжин халдварлах халдварын байгалийн голомтын болон хүн амын дундах тандал шинжилгээг Тосонцэнгэл, Их-Уул, Бүрэнтогтох, Түнэл сумдын нутаг Сэлэнгэ, Дэлгэрмөрөн голын хийж 2748 бие гүйцсэн шумуул, 1420 авгалдай, 100 хүүхэлдэй цуглуулан зүйлийн бүрдлийг тодорхойлон ЗӨСҮТ-ийн вируслогийн лабораторит шумуулаар дамжин халдварлах халдварын үүсгэгч хайх шинжилгээнд хамруулахаар хүргүүлэхэд шумуулаар дамжин халдварлах халдварын үүсгэгч илрээгүй.


Хүн амын дунд хийсэн тандал судалгаа:

Энэ жил ЗӨСҮТ-ийн захирлын А/17 тоот тушаалаар батлагдсан “Хүн амын дундах тандал судалгааны заавар”-ын дагуу 6 сумын 673 хүн амыг хамруулан хүн амын дунд тандал судалгааг хийсэн.Үүнд:

- Цагаан-Уул сумын Агар багт тарваган тахал, боомын,
- Мөрөн сумын 13 багт галзуу, хачгаар дамжих халдварын,
- Тосонцэнгэл, Их-Уул, Бүрэнтогтох, Түнэл сумын 7 багт шумуулаар дамжих халдварын мэдлэг, хандлага, эрсдэлийн түвшинг тогтоох тандал судалгааг тус тус хийж үр дүнг үнэлэхэд судалгаанд хамрагдагсдын мэдлэгийн түвшин хангалттай боловч дадал хандлага нь хангалтгүй байв.

Ариутгал халдваргүйтгэлийн талаар

Энэ жил нийт 76 аж ахуй нэгжийн 22659м.кв талбайд шавьжгүйтгэл, халдваргүйтгэл хийлээ.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗӨСТ-ИЙН СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН НЭГЖ